

**Төв аймгийн
Стандарт, хэмжил зүйн хэлтэс**

ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТЫН ТАЙЛАН

2024 ОН

СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ, СТАНДАРТЫН САЛБАР САНГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ

1. 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдөр



“Стандартын хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх”, “Залуучуудын манлайлал-Гэр бүлийн хөгжлийг дэмжих” урианы жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд Төв аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 11,12 дугаар ангийн сурагчдад Стандартын талаар мэдлэг ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгууллаа. Сургалтад 60 сурагчид хамрагдаж **“СТАНДАРТТАЙ -МОНГОЛ”** **НӨЛӨӨЛЛИЙН АЯНД НЭГДЛЭЭ.**



2. 2024 оны 04 дүгээр сарын 14-нд Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III, “Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая-2025” аяны хэрэгжилтийг эрчимжүүлэх, 2025 онд төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл хангах ажлын хүрээнд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нар, архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад танхимаар, 27 сумдын хэлний бодлогын салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар, ЗДТГ-ын дарга, ЕБС-н захирал, цэцэрлэгийн эрхлэгч, ЭМТ-ийн дарга, Соёлын төвийн дарга, байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад цахимаар дараах стандартуудаар танилцуулга, мэдээлэл хийв.



- Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо.Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдгийн байршил -**MNS 7004:2023**
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуй нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага -**MNS 5283:2022**

- Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага -**MNS 6978:2022**
- Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага -**MNS 6395:2022**

Стандартын сургалт, мэдээлэлд нийт 140 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.



3. 2024 оны 04 дүгээр сарын 17-нд Их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит Төв аймгийн Нийтийн номын сангаас жил болгон зохион явуулдаг "Сум, сургуулийн номын санчдыг чадавхжуулах" сургалтын хүрээнд тус хэлтсээс “Байгууллагын стандарт боловсруулах арга зүй” стандартаар сургалт, мэдээлэл хийж ажиллалаа. Сургалтад 27 сумын 62 номын санч хамрагдав.



4. Аймгийн хэмжээнд стандартын хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийг хүртэл “Стандартай монгол” 1 сарын нөлөөллийн аяныг зарлан удирдамж, чиглэлийг 27 сумын Засаг дарга нарт хүргүүлсэн. Уг аяны хүрээнд Бүрэн, Баян, Баянцогт, Лүн, Эрдэнэ сумын ЗДТГ, Эрдэнэ сумын ИТХ нэгдэж тус хэлтсээс танхим болон цахимаар дараах сэдвүүдээр сургалт мэдээлэл авсан. Сургалтад 5 сумын ЗДТГ, ИТХ, СӨБ, ЭМТ, ЕБС-ын 102 төрийн албан хаагчид хамрагдсан. Сургалтын сэдэв:

- Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт








- MNS 5021-1; MNS 4946 болон хүнсний үйлдвэрлэлд мөрдөх стандартын талаар
- Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо.Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдгийн байршил -MNS 7004:2023
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуй нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага -MNS 5283:2022
- Төрийн албан хаагчийн нэрийн хуудсанд тавих ерөнхий шаардлага -MNS 6978:2022
- Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага -MNS 6395:2022
- Байгууллагын стандарт, боловсруулах арга зүйн



МЕНЕЖМЕНТИЙН ТОГТЛООНЫ СТАНДАРТУУД			
Менежментийн тогтолцооны стандартын нэр	Дугаар	Үйлдсэн Байгосон	
Мөнхжил	ISO 9001:2015	2016	18
Байршил, орчны	ISO 14001:2015	2016	-
Хүнсний аюулгүй байдалын	ISO 22000:2018	2019	-
Эрчим хүчний удирдлагын	ISO 50001:2018	2018	-
Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалын	ISO 45001:2018	2018	-
Мэдээллийн аюулгүй байдалын	ISO/IEC 27001:2013	2021	-
Боловсролын байгууллагын	ISO 21001:2018	2021	-
Адил ялалт автал агуулгын	ISO 21101:2014	2022	-
Төлөөллийн тэмдэг агуулгын	ISO 37001:2016	2017	-
Бизнесийн тасралтгүй байдалын	ISO 22301:2019	2020	-
Мэдээллийн менежментийн	ISO 30401:2018	2021	-
Нийцлийн	ISO 37301:2021	2022	-
Эрсдэлийн менежмент	ISO 31000:2018	2020	-
ISO 9001 стандартыг орон нутгийн засаг захиргаанд хэрэглэх арга зүйн заавар	ISO 18001:2019	2020	-

ЭМГ, ХХУГ, ОБГ, НДХ, Нээдсэн эмнэлэг, АЗДТГ, Зуунмод сумын ЗДТГ, 6-н баг, Эрдэнэ сумын ЗДТГ



ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧИЛЖ, ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ



1. Дэлхийн усны өдрийн тохиолдуулан Байгаль орчны газартай хамтран “Хүмүүн цогцолбор” сургуулийн 9 дүгээр ангийн 45, 11 р ангийн 30 нийт 75 сурагчдыг хамруулан “Усны үнэ, цэнэ” сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр усны хими, нян судлалын сонирхолтой



сорилт туршилтуудыг хүүхдүүдтэй хамтран хийж сурагчдын усны тухай болон хими, биологийн мэдлэгийг дээшлүүлсэн, үр дүнтэй арга хэмжээ болов. Мэдээллийг байгууллагын пэйж хуудсаар сурталчилсан.



2. Төв аймгийн Политехникийн коллежийн химийн багш С.Хишигтийн хүсэлтийн дагуу тогоочийн ангийн 45 оюутанд лабораторийн үйл ажиллагааг танилцуулан сурталчилж, “Эрүүл ахуйн халдвар хамгаалал, хоол үйлдвэрлэлийн зохистой дадал” сургалтыг зохион байгуулж, хими, нян судлалын шинжилгээний сонирхолтой туршилтыг хийж үзүүлэв.




СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ


Тохирлын үнэлгээ, баталгаажуулалттай холбоотой хууль тогтоомж, баталгаажуулалтын ажил үйлчилгээнд мөрдөгдөх төлбөр, MNS 5021-1; MNS 4946 болон хүнсний үйлдвэрлэлд мөрдөх стандартын талаар 27 сумдын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарыг 4 удаагийн сургалт цахимаар болон танхимаар зохион байгуулж **нийт 260** /давтагдсан тоогоор/ аж ахуй нэгж, иргэдийг хамруулсан байна.



1. 2024 оны 04 сарын 04-ний өдөр Тохирлын үнэлгээ, баталгаажуулалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, баталгаажуулалтын ажил үйлчилгээнд мөрдөгдөх төлбөр, MNS 5021-1; MNS 4946 болон хүнсний үйлдвэрлэлд мөрдөгдөх стандартуудын талаар сумдын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарыг хамруулан цахимаар сургалт зохион байгуулав. Сургалтад 8 сумын 60 үйлчилгээ эрхлэгч нар хамрагдсан.



2. “Хүнсний хангамж–Аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан аянд тус хэлтсийн Бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн Ж.Түвшинсүрэн “Тохирлын үнэлгээ, баталгаажуулалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, баталгаажуулалтын ажил үйлчилгээнд мөрдөгдөх төлбөр” сэдэвт сургалтыг 27



сумын бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэгч 157 иргэн, ААН-д цахимаар сургалт зохион байгуулав.

3. “СТАНДАРТТАЙ МОНГОЛ” аяны хүрээнд 05-р сарын 15-ны өдөр Бүрэн сумын худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт “Тохирлын баталгаажуулалт, тохирлын гэрчилгээ хэрэглэх ач холбогдол” “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5021-1:2023 стандарт” сэдэвт сургалтад 15 ААН, иргэн хамрагдлаа.



4. Дэлхийн хэмжил зүйн өдрийг тохиолдуулан “Бид тогтвортой маргаашийн төлөө өнөөдөр хэмжиж байна” уриатайгаар 05-р сарын 17-ны өдөр Эрдэнэ суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж байгууллагын үйл ажиллагаа сурталчлан худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт “Тохирлын үнэлгээ, баталгаажуулалттай холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, баталгаажуулалтын ажил үйлчилгээнд

мөрдөгдөх төлбөр” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалт, мэдээлэлд нийт 28 ААН, иргэн хамрагдлаа.

2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтсээс Төв аймгийн 27 сумын ЗДТГ, ИТХ, Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, архив бичиг хэргийн ажилтнууд, 27 сумын СӨБ, ЭМТ, ЕБС, МСҮТ, Ерөнхий боловсролын сургуулийн 9,11,12 дугаар ангийн сурагчид, Аймгийн нийтийн номын сангийн албан хаагчид, 27 сумын ЖДҮ- хариуцсан мэргэжилтэн, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүй, сорилтын лабораторийн чиглэлээр 15 удаагийн сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж 773 иргэнийг хамруулан ажилласан.

ТАНИЛЦСАН ДАРГА

Д.БАТСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН
СМ,ССС-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

У.БАТТУЯА